

Байгаль Орчны Шинэчлэл-2 төслийн саналыг цахим шуудангаар хүлээн авах журам

Төслийн уралдаанд цахим шуудан буюу и-мэйлээр ирж буй төслийн тоо жил бүр ихсэж байгаа бөгөөд өмнөх жилүүдэд төсөл явуулах, хүлээн авах болон бүртгэх үйл ажиллагаанд гарч байсан хүндрэлтэй асуудлуудыг шийдэх үүднээс дараах журмыг гаргаж байна. Иймд project@forum.mn хаягаар төслөө явуулж буй байгууллага, хувь хүн бүр дараах журмын дагуу төслөө илгээнэ үү.

1. И-мэйлийн гарчиг (subject) дээр төслийн нэрийг латинаар бичих.
2. И-мэйл болон хавсралтын хэмжээ 10 Мб-аас ихгүй байх. Том хэмжээний файлууд хавсаргаж и-мэйлийн багтаамж хэтэрсэнээс таны и-мэйл ирэхгүй байх, буцаагдах магадлалтай. Хэрэв таны и-мэйлийн хэмжээ их байгаа бол хувааж явуулах шаадлагатай. Энэ тохиолдолд и-мэйлүүдээ дугаарлах шаардлагатай. Жишээ нь: Dundgovi-nogoon orchin tusul-1; Dundgovi-nogoon orchin tusul-2 гэх мэт ...
3. Нэг и-мэйлд нэг төсөлтэй холбоотой материалуудыг хавсаргаж явуулах. (2-3 төслийн материалыг нэг и-мэйлээр явуулах нь зарим нэг зүйл орхигдох магадлалыг бий болгодог)
4. Нэг файлд нэг төслийн санал байх. (Нэг файлаар хэд хэдэн төслийн саналыг явуулах тохиолдол их гардаг ба энэ нь төслийн давхцал болон төслийн материал орхигдох магадлалыг бий болгохоос гадна бүртгэлийн ажиллагаанд хүндрэл учруулдаг)
5. Төслийг Улаанбаатарын цагаар 18 цагаас өмнө илгээсэн байх (Төсөл илгээсэн огноо нь Улаанбаатарын цагаар 18 цагаас өмнө байгаа тохиолдолд тухайн төслийг бүртгэлд оруулна. Иймд цагийг нь тулгаж и-мэйл явуулснаас үүсэх эрсдэлийг тооцож аль болох эрт төслөө явуулах шаардлагатай.
6. Хавсралт файлд нууц үг хийхгүй байх. (Төслөө хугацаанд нь ирүүлсэн боловч төсөл бичсэн файлаа нууц үгтэй хадгалснаас төслийг нээж үзэх боломжгүй хэд хэдэн тохиолдол гарч байсан.
7. Төсөл болон төсөлд хавсаргагдах файлуудыг интернэтэд байршуулахгүй байх. (Өмнөх жил интернэтэд байршуулсан төслүүдийг татан авахад хүндрэлтэй байсан тул төслийг зөвхөн и-мэйлээр болон биечлэн авчирч өгөх шаардлагатай)
8. И-мэйл явуулахдаа холбогдох утас (2-оос доошгүй) хаягаа тодорхой бичиж явуулах
9. Төслөө pdf форматаар явуулбал сайн. /төслийн хуудас бүрийг зураг хэлбэрээр сканэрдэж явуулдагаас файлийн хэмжээ хэт томорч и-мэйл явуулахад хүндрэлтэй болдог/
10. Төслөөр ирүүлэх ёстой материалууд бүрэн байх. (Материалын бүрдэл дутуу төслийг бүртгэж авах боломжгүй учир удирдамжид заасны дагуу шаардлагатай материалыг бүрэн илгээх шаардлагатай. Хэрвээ 2 болон 3 и-мэйлээр 1 төслийн материалыг хуваан явуулж байгаа бол 1-р заалтын дагуу и-мэйлийн гарчиг дээр төслийн нэрийг заавал бичих шаадлагатай.
11. Төслийг давхардуулж явуулахгүй байх (2-3 өөр и-мэйл хаягаас 1 төслийн материалыг явуулахгүй байх)

Та бүхэн и-мэйлээ дээрхи журмын дагуу явуулбал бид таны төслийг саадгүй хүлээн авах болно. Та бүхэнд амжилт хүсье.